



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 4623

Улаанбаатар хот

Үйлчилгээний төлбөрийн хэмжээг
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/A/118 дугаар тушаал, Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус эмнэлгийн үйлчлүүлэгчид үзүүлж буй зарим үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Энэ тушаалыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эмнэлзүй хариуцсан дэд захирал (Ц.Ганзориг), эмнэлгийн тусламжид шаардлагатай хэвтүүлэн эмчлүүлэх орны тооцоо судалгааг гаргаж, зохицуулалтыг тогтмол хийхийг Эдийн засаг, төлөвлөлтийн албаны дарга (Ч.Ганхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шинэчлэн баталсан үйлчилгээний орлогыг байгууллагын кассаар дамжуулан Төрийн сан дахь харилцах дансанд төвлөрүүлэхийг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч (Б.Ариунболд)-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Төлөвлөлт, эдийн засаг, маркетинг хариуцсан дэд захирал (Э.Анхбаяр)-д даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны А/72 дугаар тушаалын хавсралтын 5 дугаар багана (нэг ор хоногийн тариф)-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Улсын хоёрдугаар төв эмнэлгийн
Ерөнхий захирлын 2023 оны 03
дугаар сарын 04 өдрийн
дугаар тушаалын хавсралт



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/Д	Тусламж, үйлчилгээний нэр, төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	Нөхцөл сайжруулсан өрөөний үйлчилгээ 1 ор хоног (1 ортой)	60,000
2	Нөхцөл сайжруулсан өрөөний үйлчилгээ 1 ор хоног (2 ортой)	30,000
3	Захиалгат хоол (өглөө)	7,000
4	Захиалгат хоол (өдөр)	15,000
5	Захиалгат хоол (орой)	15,000